



## МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2020 оны 07 сарын 28 өдөр

Дугаар 146

Улаанбаатар хот

### Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд бүртгэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5 дахь хэсэг, 52 дугаар зүйлийн 52.1.14 дэх заалт, “Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлийг хөтлөх журам”-ын 2.4, Худалдан авах ажиллагааны улсын байцаагч, ахлах байцаагчдын саналыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд хамруулах этгээдийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлийн мэдээллийг худалдан авах ажиллагааны цахим системд олон нийтэд нээлттэй байршуулахыг Худалдан авах ажиллагааны бодлогын хэлтэс /Ц.Батзул/-т, тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг захиалагч нарт даалгасугай.



Ч.ХҮРЭЛБААТАР

9767 00274

**Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн  
бүртгэлд хамруулах этгээдийн жагсаалт**

№	Эрхээ хязгаарлуулсан этгээдийн нэр, регистрийн дугаар	Бүртгэлд хамруулсан үндэслэл	Улсын байцаагчийн шийдвэр, шүүхийн тогтоолын дугаар, огноо	Бүртгэлд хамруулсан огноо
1	“Мөлүүхээр” ХХК /5872804/	Үйлдвэрлэгчийн зөвшөөрөл хуурамчаар үйлдсэнийг Захиргааны хэргийн Анхан шатны шүүх болон улсын байцаагч тогтоосон.	Худалдан авах ажиллагааны улсын байцаагчийн 2020.06.11-ний өдрийн УБ/08 дугаар дүгнэлт	2020 оны 07 дугаар сарын 28-ны өдөр
2	“Тэгш өргөө” ХХК /5362156/	Авто зам, замын байгууламжийг барих, засварлах тусгай зөвшөөрлийг хуурамчаар үйлдсэнийг улсын байцаагч тогтоосон.	Худалдан авах ажиллагааны улсын байцаагчийн 2020.06.11-ний өдрийн УБ/07 дугаар дүгнэлт	2020 оны 07 дугаар сарын 28-ны өдөр
3	“Бүрд-Уул” ХХК /5196604/	“Юнисервис солюшн” ХХК-тай байгуулсан “Ариун цэврийн материал нийлүүлэх” гэрээг хуурамчаар үйлдсэнийг улсын байцаагч тогтоосон.	Худалдан авах ажиллагааны улсын байцаагчийн 2020.07.08-ний өдрийн УБ/10 дугаар дүгнэлт	2020 оны 07 дугаар сарын 28-ны өдөр
4	“Кристалхилл капитал” ХХК /5196604/	Батлан хамгаалах яамны 2019 оны 22 дугаартай “Гал тогооны тоног төхөөрөмж нийлүүлэх” гэрээ, тус яамны 2020 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн 1в/160 дугаар албан бичгүүдийг хуурамчаар үйлдсэнийг улсын байцаагч тогтоосон.	Худалдан авах ажиллагааны улсын байцаагчийн 2020.07.08-ний өдрийн УБ/11 дугаар дүгнэлт	2020 оны 07 дугаар сарын 28-ны өдөр